

- ХДХВ / ДОХ-оос урьдчилан сэргийлэх талаар хүн амын мэдлэг, хандлага, туршлагыг тодорхойлох туршилтын судалгаа

ХДХВ / ДОХ-оос урьдчилан сэргийлэх талаар хүн амын мэдлэг, хандлага, туршлага ямар байгааг тодорхойлох зорилгоор 1999 онд хийгдсэн уг судалгаа нь галт тэргээр зорчигчид болон төмөр замын дагуу оршин суугчдын дунд хийгдсэн анхны судалгаа юм. Судалгааны дүнгээс харахад ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг хариулагчдын дунд тийм ч тааруу биш байлаа. Харин өсвөр үе, залуучууд, боловсролын түвшин бага, ажил эрхэлдэггүй, огт гэрлээгүй буюу ганц бие залуучуудын дунд харьцангуй бага байв. 24-өөс доош насны хариулагчдын 25% нь ХДХВ/ДОХ-ын талаар найз нөхөд болон хүмүүсийн ярианаас сонссон гэж хариулсан байна. Мөн энэ талаарх мэдээллийг найз нөхөд болон хүмүүсийн ярианаас авдаг гэж хариулсан ажилгүй хүмүүсийн хувь ажил эрхэлж буй болон окутан сурагчдынхаас өндөр байна. Судалгаагаар үе тэнгийнхний сургалт нэлээд ач холбогдолтой нь харагдсан. Цаашид ХДХВ/ДОХ-оос сэргийлэх ажлын хүрээнд бэлгэвчийн ач холбогдлыг таниулан сурталчлах ажлыг өргөжүүлэх шаардлага тавигдаж байна.

- Монголын ажиллах хүчний мэдлэг, ур чадварын талаарх түүвэр судалгаа

Мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжих гол нөхцлийн нэг нь өндөр боловсролтой, чадварлаг ажиллах хүчин билээ. Тиймээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тал болох пүүсүүд ямар мэдлэг боловсрол, ажлын ур чадвартай ажиллах хүчнийг эрэлхийлж байгааг судлах нь нэн чухал байгаа юм. Ингэж судалснаар хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн тал болох техник мэргэжил, их, дээд сургуулиудийн зах зээлд шаардлагатай байгаа ажиллах хүчнийг бэлтгэх асуудал улам боловсронгуй болж ирэх ач холбогдолтой юм. Энэ ажилд Монголын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн асуудлыг, тухайлбал, аж үйлдвэрлэл ба мэдээлэл технологийн салбарын пүүсүүд ямархуу мэдлэг, чадвартай ажилчид элсүүлэхийг хүсэж байгаа, ажилчдаа хэрхэн сонгон шалгаруулж авдаг, ажилчдынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэхийн тулд ямар төрлийн сургалт явуулдаг талаар хийсэн судалгааны үр дүнг багтаалаа.

- Монгол дахь нялхасын эндэгдлийн түвшин, хандлага: Эмэгтэйчүүдийн боловсролын түвшинтэй холбож тайлбарлах нь

Өнгөрсөн зууны хоёрдугаар хагасаас хөгжиж буй улс орнуудын нэгэн адил Монголд нас баралт тогтвортойгоор буурч ирлээ. Гэхдээ хүн амын нас баралтын насны хэв маяг нь нялхас, хүүхдийн нас баралт өндөр шинж байдлыг агуулсаар байна. Нялхас хүүхдийн нас баралтын өнөөгийн стандартчилагдсан ерөнхий түвшинтэй харьцуулахад Монгол дахь нялхас

хүүхдийн эндэгдэлд нийгэм, эдийн засгийн байдал, хүн ам зүйн болон орчин ахуйн хүчин зүйлс нөлөөлж байна. Аливаа улс орны нялхас, хүүхдийн нас баралтын бууралтад эмэгтэйчүүдийн боловсрол чухал нөлөөтэй гэдгийг баримт, нотолгоо харуулж байгааг дутуу үнэлэх нь зүйд нийцэхгүй боловч хүүхдийн эндэгдлийг бууруулахад эмэгтэйчүүдийн боловсрол чухам яаж тусалж байна вэ гэдэг асуулт өссөөр байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нь завсрын хүчин зүйлсээр дамжин хүүхдийн эндэгдэлд нөлөөлж байна. Эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр оролцооны түвшин дээшилж, олон нийтэд тулгуурласан гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ сайжирсаар байна. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар хүмүүсийн мэдлэг нэмэгдэхийн хэрээр (ялангуяа хөдөөгийн хүн амын) төрүүлэх хүүхдийн тоо цөөн болж байгаагаас бусад хүүхдийн чанарын асуудалд хандах хандлагад өөрчлөлт орж байна. Эдгээр орчин ахуйн бүх өөрчлөлтийн нөлөөгөөр хүүхдийн эндэгдлийг ирж буй шинэ зуундаа Монгол улс амжилттай бууруулах боломж нээгдэж байна.

□ Хүн ам ба настан

Дэлхий нийтийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн байдал сайжирч, дундаж наслалт нэмэгдэхийн хэрээр ахмад настнуудын тоо өссөөр байна. Ялангуяа төрөлтийн түвшин огцом буурч байгаа улсуудад хөгшрөлтийн процесс идэвхтэй явагдаж, улмаар настнууд анхаарал татсан асуудлын нэг болоод байгаа билээ. 1995 он гэхэд 60 буюу түүнээс дээш насны хүн амын тоо 545 сая байсан бол 2000 онд 614 саяд хүрсэн ба цаашид энэ тоо улам бүр өсч 2025 он гэхэд 1.2 тэрбумд хүрнэ. Ерөнхийдөө ахмад настнуудын дунд эмэгтэй настнуудын эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр байх хандлага аль ч орны хувьд ажиглагдаж байна. Энэхүү ажилд дэлхийн, бүсийн болон Монгол улсын хэмжээнд настнуудын талаарх зарим нэг гол асуудлыг авч үзсэн ба Монгол улсын өндөр настнуудын орлогын эх үүсвэр, эрүүл мэндийн болон гэр бүлийн байдал, орон сууцны нөхцөл зэргийг судалгааны үр дүнд үндэслэн тодорхойлсон болно.

□ Шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал

Манай улсад сүүлийн 40 гаруй жилд хотжилт мэдэгдэхүйц хурдацтай явагдаж байна. Гэхдээ хотжих үйл явц бүс нутгаар жигд байж чадаагүй бөгөөд Улаанбаатар, төмөр зам дагуу хот суурины цуваа бүрэлдэх чиглэлээр явагдсан гэж хэлж болно. НҮБ-ын ХАС-гийн санхүүгийн болон техникийн тусламжтайгаар Монгол улсын хүн амын байршил, шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй нийгэм эдийн засгийн болон хүн ам зүйн хүчин зүйлсийг судалсан судалгааг 2000 онд хийж гүйцэтгэсэн юм. Шилжих хөдөлгөөний улмаас шилжигчид эерэг сөрөг олон үр дагавартай тулгарч

буйг судалгааны үр дүн тодорхойлж өглөө. Иймээс хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбогдсон ашиг сонирхол, зөрчлийг зөөлрүүлэх талаар уян хатан, алсын хараатай төрийн бодлого явуулахад шилжих хөдөлгөөнийг зохистой механизмаар залуурдах, арга, чиглэлийг нарийвчлан тодорхойлж өгсөн төрөөс баримтлах хүн амын бодлого өөрчлөн гаргах шаардлага амьдралаас урган гарч байна.

- Монголын хэрэглэгчийн зах зээл дэх хэрэглэгчдийн тоо, байршил, бүтцийн судалгаа

Хувийн хэрэглээнд зориулж бараа үйлчилгээг худалдан авч байдаг хүн, өрх гэрүүдийн нийлбэрээс хэрэглэгчийн зах зээл бүрддэг. Монголын хэрэглэгчийн зах зээл дээр 2000 оны байдлаар 2407.5 мянган хүн ам, үүнээс хотын хүн ам 57.2%, хөдөөгийн хүн ам 42.8%-ийг эзэлж байгаа ба нийслэлд бараг 3 хүн тутмын нэг нь амьдарч байна. 0-39 насны хэрэглэгчид нийт хүн амын 81.12%-ийг эзэлж байгаа нь манай орон дэлхийн бусад орнуудаас ялгарах гол онцлогуудын нэг юм. 554.0 мянган өрх тоологдсны 30.18% нь нийслэлд харъяалагдаж байна. Нэг өрхөд ноогдох хүний дундаж тоо 4.3 хүн байгаа ба энэ нь 1980 оноос 0.8 хүн, 1990 оноос 0.3 хүнээр буурсан хэрэг юм.

- Зах зээлд шилжих үеийн Монгол Улсын хотжилтын зарим онцлог

Хотод оршин суугчдын тоо 1997 оныг хүртэл жилээс жилд өсөж байсан төдийгүй, нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жин нэмэгдэж байна. Харин сүүлийн 2 жилийн дотор хотод оршин суугчдын тоо ялимгүй буурсан нь зарим аймгийн төвийн хүн амын тоо буурсантай холбоотой. 1963 онд нийт хүн амын 40 орчим хувь, 1989 онд нийт хүн амын 57%, 1999 онд нийт хүн амын 51% нь хотын хүн ам байна. 1990 онтой харьцуулахад Улаанбаатарт оршин суугчдын тоо өсч, нийт хүн амын 28%, хотын хүн амын 54% нь төвлөрч байна. Мандалговь, Баруун-Урт, Цэцэрлэг хотуудын байнгын оршин суугчдын тоо цөөрч, нийгэмд гүйцэтгэх үүрэг нь өөрчлөгдсөн боловч хотжилтын үйл явц үргэлжилсээр байна.

- Монголын хүн амын нас, хүйсийн бүтцэд гарч буй өөрчлөлтүүд, түүний үр нөлөө

Энэхүү ажилд Монгол улсад явагдсан хүн амын тооллогын мэдээллүүдийг эх үүсвэр болгон 2000 он хүртэлх Монгол улсын хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтөд судалгаа хийсэн ба судалгааны үр дүнгээс үзэхэд энэ зууны эхний хагасаас өмнө ихээхэн зохисгүй байдалтай байсан хүн амын насны бүтэц төрөөс хүн амынхаа есөлтийг дэмжих талаар явуулсан идэвхтэй бодлогын дүнд өнөөдөр харьцангуй зөв хэлбэртэй болоод байна.

Сүүлийн хагас зуун жилд манай орон залуу хүн амтай оронд тооцогдож байгаа ба 1956-1980-аад оны хүн амын залуужилтыг тодорхойлогч гол бүлэг нь хүүхдүүд байсан бол, 1980-аад оноос хойш уг бүлэг нь өсвөр үеийнхэн болон хөдөлмөрийн эгнээнд шинээр шилжиж буй насныхан болжээ. Иймээс ч хүн амын одоогийн насны бүтэц нь цаашдын хүн амын өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх боловч одоогоор дээд боловсрол, орон сууц, ажлын байрны ихээхэн хэрэгцээг бий болгож, сүүлийн үед манай оронд газар аваад байгаа ядуурал, ажилгүйдэл гэх мэт нийгэм эдийн засгийн сөрөг үзэгдлүүдэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөөр байна.

□ Нийгмийн судалгаанд статистик аргыг ашиглах нь

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн хамгийн чухал үзүүлэлтийн нэг нь хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтүүд байдаг. Амьжиргааны түвшинг нэгтгэн харуулах ерөнхий үзүүлэлт байхгүй учраас түүнийг статистикийн олон үзүүлэлтээр тодорхойлдог. Энэ ажилд хүн амын орлогын ялгаа, ядуурлын түвшин, хязгаарлалтыг судлах аргууд, мөн нэгдсэн үзүүлэлтээр харуулах боломжийн тухай авч үзэх болно. Үүнд: Олон улсын статистикт өргөнөөр хэрэглэдэг индексийн болон загварчлах аргуудыг голлон авч үзсэн ба Монгол улсын хүн амын нэг хүнд ногдох сарын дундаж орлогын мэдээг үндэслэн орлогын ялгааны үзүүлэлтийг тооцож үзсэн. Ингэхэд хамгийн өндөр болон хамгийн бага орлогын түвшинтэй хүн амын нэг хүнд ногдох орлогын түвшин маш их зөрүүтэй гарсан байна. Мөн амьжиргааны түвшний хамгийн гол үзүүлэлтүүдийг нэгтгэсэн байдлаар харуулах хүний потенциалын хөгжлийн индекс Монгол улсын хувьд 0.513 байна.

□ Хүн ам зүйн хөгжлийн удирдлагыг боловсронгуй болгох арга зам

Даяарчлалын үйл явцтай уялдуулан аливаа улс орон хөгжлийн үзэл баримтлалаа эргэн харж, удирдлага, төлөвлөлт, прогнозчлынхоо хувилбар, парадигмыг өөрчилж, нэмэлт тодотгол хийж байна. Монголын өнөөгийн хүн ам зүйн хөгжлийн удирдлага нь дотроо ерөнхий ба тусгай хэмээн хоёр хуваагдахаар байна. Хүн ам зүйн хөгжлийн ерөнхий удирдлага нь улс орны хөгжлийн суурь үзэл баримтлалтай холбоотой, нийтлэг эрх ашгаар нөхцөлдөх учиртай харин тусгай удирдлага нь монгол улсын хүн ам зүйн хөгжлийн үйл явцаар л тодорхойлогдоно. Хүн ам зүйн хөгжлийн ерөнхий ба тусгай бодлого нь үйлчлэх хүрээ, механизм, нөлөөллийнхөө хэр зэргэмжээр харилцан адилгүй ч, бие биенийгээ тэтгэн дэмжсэн, нөхөн сэлбэсэн шинжтэй байна. Цаашид Монголын хүн ам зүйн хөгжлийн удирдлагын тогтолцоонд нийгмийн ба төрийн удирдлага, тэдгээрийн харьцаа, шүтэлцээг сайжруулах, хүн ам зүйн зохицуулалт төлөвлөлт, прогнозчлолын асуудалд анхаарах, хүн ам зүй, хүний нөөцийн асуудлыг шинжлэх ухааны түвшинд хүргэх шаардлага урган гарч байна.